

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР №28

Хуралдаан 2013 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 11 цаг 00 минутад эхэлж, 14 цаг 16 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 3 цаг 16 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p> <ul style="list-style-type: none">- Баян-Өлгий, Баянхонгор, Увс, Орхон, Хөвсгөл аймаг- Үйлдвэр хөдөө аж ахуйн яам, Хүний Эрхийн Үндэсний комисс, Үндсэн хуулийн Цэцийн Тамгын газар, Дээд шүүхийн Тамгын газар, Цаг уур орчны шинжилгээний газар, Худалдан авах ажиллагааны газар	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 10 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн Тамгын газар, Монгол Улсын Дээд Шүүхийн Тамгын газар, Хүний эрхийн Үндэсний комиссын Ажлын алба, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Худалдан авах ажиллагааны газар, Цаг уур орчны шинжилгээний газрын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын 17 - ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <ol style="list-style-type: none">1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нийт 36 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1 дүгээр хавсралтаар батлах2. Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан “Дэс түшмэлийн ангиллын

төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 17 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлснийг 2 дугаар хавсралтаар батлах.

3. Энэхүү тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан нэр бүхий 17 иргэнийг "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан тус тусын албан тушаалд томилохыг тухайн эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгох.

1. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам"-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 09 дүгээр сарын 26-аас 10 дугаар сарын 07-ны өдрүүдэд Баян-Өлгий, Баянхонгор, Увс, Орхон, Хөвсгөл аймагт тус тус зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын 17 -ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :

2. Баян-Өлгий, Баянхонгор, Увс, Орхон, Хөвсгөл аймагт 2013 оны 09 дүгээр сарын 26-аас 10 дугаар сарын 07-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад

		<p>тэнцсэн нийт 113 иргэнээс 81 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 32 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 53 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 13 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>4. Энэхүү тогтоолын 9-16 дугаар хавсралтаар баталсан нэр бүхий 66 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Баян-Өлгий, Баянхонгор, Увс, Орхон, Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.</p> <p>5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	--

2	<p>Говьсүмбэр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Чимэд-Очирын Батжаргалыг Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх</p> <p>2. Энэ тогтоолын нэгдүгээрт нэр заасан иргэн Чимэд-Очирын Батжаргалыг Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Баянжаргалд санал болгох. тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Боловсрол, шинжлэх ухааны яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд тус яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Ш.Булга-Эрдэнийн 2013 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 07 тоот албан бичгээр Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар</p>

		нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулахаар тогтлоо.
4	Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргуулах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд Пушаагийн Алтан-Одод дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтангэрэлд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	Гадаад харилцааны яаманд ажиллаж байсан Ц.Чингарьдаас гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай	<p>Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын гуравдугаар нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Ц.Чингарьдаас тус яамны Төрийн нарийн бичгийн даргын “Сахилгын шийтгэл ногдуулах тухай” 2013 оны Б/217 дугаар тушаалыг эс зөвшөөрч, Төрийн албаны зөвлөлд гаргасан гомдол үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай</p>

		<p>холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам"-ын "Нэг" дэх хэсгийн 3.4-ын "д"-д заасныг удирдлага болгох нь:</p> <p>1. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын "Сахилгын шийтгэл ногдуулах тухай" 2013 оны Б/217 дугаар тушаалыг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх.</p> <p>2. "Сахилгын шийтгэл ногдуулах тухай" 2013 оны Б/217 дугаар тушаалыг хүчингүй болгож шийдвэрлэхийг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Цогтсайханд даалгах.</p> <p>3. Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д заасны дагуу энэхүү тогтоолын 2-т заасныг биелүүлэхийг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Цогтсайханд үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7-д заасны дагуу шүүхэд гомдлоо гаргах эрхтэй болохыг маргааны талуудад мэдэгдэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	Зарим байгууллагаас Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөл байгуулахаар ирүүлсэн саналын тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас:</p> <p>1.Монгол Улсын Их Хурлын 2009 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 87 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3 дахь заалтын "агентлагт" гэсний өмнө "Шүүхийн ерөнхий зөвлөл" гэж нэмэх.</p> <p>2.Дээрх дүрмийн "Гурав"-ын 3.7.2 дахь заалтын "...Шүүхийн ерөнхий зөвлөл" гэснийг хасах гэсэн саналыг Монгол Улсын Их Хуралд хүргүүлэх нь зүйтэй гэж үзэв.</p>

		<p>Мөн "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.7-д "...Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, ...Үндэсний статистикийн хорооны ажлын албаны боловсон хүчний холбогдолтой асуудлыг Төрийн албаны зөвлөл хариуцна" гэж заасан бөгөөд "Төрийн албаны тухай хууль"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэх гэж байгаа энэ үед Салбар зөвлөл байгуулах тухай асуудлыг УИХ-д оруулах нь цаг хугацааны хувьд боломжгүй" хэмээн үзэж байгаагаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний статистикийн хороо, Засгийн газрын тохируулагч агентлаг Цөмийн энергийн газарт албан бичгээр хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>
7	Зарим албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйл, "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг батлах тухай" Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан журмын 2, 6 дахь заалт, "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын 2000 оны 20 дугаар тогтоолын 1-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргын 2013 оны 1090 тоот албан бичгээр тус Ажлын албаны ахлах референт Т.Сосорбарамд төрийн захиргааны албан тушаалын эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулах саналыг хэлэлцээд, эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулах саналыг Засгийн газарт уламжлахаар шийдвэрлэв.</p>
8	Төрийн албаны мэргэшлийн шалгалт цахим хэлбэрт шилжсэн тухай тайлан	<p>Төрийн албаны мэргэшлийн шалгалт цахим хэлбэрт шилжсэн тухай тайланг сонсож хэлэлцээд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Цахим сүлжээ, программыг боловсронгуй болгох чиглэлээр "Интерактив" компанитай хамтарч

		<p>ажиллах, өөрсдийн тавьж байгаа шаардлагаа боловсруулах</p> <p>2. Төсөл бичих, хөрөнгө мөнгөний тооцоо судалгаа гаргах,</p> <p>3. Цахим системийн аюулгүй байдлыг илүү сайн хангах</p> <p>4. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын шинэ сорилыг хэвлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэв.</p>
9	"Төрийн албаны мерит тогтолцоо: Туршлага сургамж, сорилт боломж" Олон улсын чуулга уулзалтын үр дүнгийн тухай	<p>"Төрийн албаны мерит тогтолцоо: Туршлага сургамж, сорилт боломж" Олон улсын чуулга уулзалтын үр дүнгийн тухай хэлэлцээд:</p> <p>1. Төрийн албаны төв байгууллагуудын Улаанбаатарын чуулга уулзалт "Төрийн албаны мерит тогтолцоо: туршлага сургамж, сорилт боломж" сэдвийн дор төлөвлөсөн ёсоор амжилттай болж, тавьсан зорилгоо хангасан гэж үзэх</p> <p>2. Олон улсын чуулга уулзалтад тавигдсан илтгэлүүдийг англи, монгол хэлээр хэвлүүлэн нийтийн хүртээл болгох</p> <p>3. Чуулга уулзалтын арга хэмжээг зохион байгуулахад онцгой идэвх зүтгэлтэй ажилласан зарим хүмүүс /Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн Т.Хадхүү, ахмад дипломатч О.Нямдаваа нар/-ийг "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнаж, Ажлын хэсгийн гишүүдэд мөнгөн урамшуулал олгохоор Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаас шийдвэрлэлээ.</p>
10	Хөвсгөл аймагт ажилласан Ажлын хэсгийн тайлан	<p>Төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөж, төрийн жинхэнэ албан тушаалтныг томилохдоо Төрийн албаны тухай хууль, УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон</p>

		<p>шалгаруулах журам"-ыг баримтлахыг сануулж, гаргасан зөрчлийг 2013 оны 12 дугаар сарын 10-ны дотор арилган, хариу мэдэгдэхийг Хөвсгөл аймгийн Засаг даргад зөвлөж, Засаг даргын Тамгын газрын даргад албан даалгавар хүргүүлэхээр, Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангийн үзүүлэлтийг боловсронгуй болгох Ажлын хэсэг гаргахаар шийдвэрлэлээ.</p>
11	Бусад асуудал	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "б"-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Бодлого, зохицуулалтын газрын даргын албан тушаалд Дониогийн Цогт-Очирт дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

